



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН  
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН  
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2018 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 235

Дархан сум

Зохигчдын эвлэрлийг баталж,  
хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Хэргийн индекс 135/2018/01135/и

Дархан-Уул аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч  
З.Тунгалагмаа даргалж, тус шүүхийн танхимд хийсэн шүүх хуралдаанаар,

Нэхэмжлэгч: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16А,  
Засгийн газрын 9 дүгээр байр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал  
хамгаалах сан /РД: 5451973, утас 453233/-ийн нэхэмжлэлтэй.

Хариуцагч: Дархан-Уул аймаг, Дархан сум, 5 дугаар багт үйл ажиллагаа явуулдаг  
"Энсатрактрон"ХХК /РД: 455801/-д холбогдох

"323,805,000 төгрөг гаргуулах тухай" иргэний хэргийг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Бат-Өлзий,  
хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Энхтөр, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга  
М.Алтантуяа нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

Зохигчид шүүх хуралдаан дээр байгуулсан эвлэрлийн гэрээндээ:

"...Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны мал хамгаалах сан нь 323,805,000  
төгрөгийн нэхэмжлэл өгснөөс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад 235,000,000  
төгрөгийн үндсэн төлбөрийг төлж барагдуулсан ба 20,000,000 төгрөгийг алданги  
хэлбэрээр төлөхөөр тохиролцов. 20,000,000 төгрөгийн алданги төлөх хуваарь

- 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор 10,000,000 төгрөг
- 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор 10,000,000 төгрөг төлж  
барагдуулна.

Алданги болох 88,805,000 төгрөгөөс 20,000,000 төгрөгөөр тохирч үлдсэн 68,805,000  
төгрөгийн нэхэмжлэлээс татгалзаж байна" гэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал хамгаалах сан нь  
хариуцагч "Энсатрактрон" ХХК-д холбогдуулан 323,805,000 төгрөг гаргуулах тухай  
нэхэмжлэлийн шаардлагыг гаргажээ.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч Энсатрактрон ХХК нь  
нэхэмжлэлийн шаардлагаас 235,000,000 төгрөгийг төлсөн бөгөөд нэхэмжлэгч тал  
нэхэмжлэлийн шаардлагын үлдэх хэсэг болох 88,805,000 төгрөгийн 68,805,000 төгрөгөөс  
татгалзаж, хариуцагч тал үлдэх 20,000,000 төгрөгийг 2018 оны 12 дугаар сарын 25-ны  
өдөр 10,000,000 төгрөг, 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 10,000,000 төгрөгийг тус тус  
төлөхөөр харилцан тохиролцжээ.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.5-т Энэ хуулийн 106.3, 106.4-т зааснаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, зохигч эвлэрсэн нь бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй, хуульд харшлаагүй бол шүүх хариуцагчийн зөвшөөрөл, нэхэмжлэгчийн татгалзал, зохигчийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шүүгч захирамж, шүүх тогтоол гаргана. Эдгээр тогтоол, захирамжид энэ хуулийн 74.4-т заасан зохицуулалт нэгэн адил хамаарна” гэж заасныг баримтлан зохигчдын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д заасныг удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.5-д зааснаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал хамгаалах сангийн нэхэмжлэлтэй, хариуцагч “Энсадатрактрон” ХХК-д холбогдох иргэний хэрэгт зохигчдын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.6, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-т зааснаар нэхэмжлэгч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал хамгаалах сан гв улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөгдсөн болохыг дурдаж, хариуцагч Энсадатрактрон ХХК-аас улсын тэмдэгтийн хураамж 1,432,950 төгрөгийг гаргуулж Төрийн сангийн орлогод оруулсугай.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.6-д зааснаар энэхүү захирамжийг хариуцагч сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэсүгэй.

4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.4-д зааснаар хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн тул зохигчид давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, энэ асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ  З.ТУНГАЛАГМАА